



**УВС АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН  
АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН  
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 318/ЗТ2026/00001

Улаангом сум

Нэхэмжлэл, иргэний хэрэг, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам батлах тухай

Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч Б.Гансүх даргалж, шүүгч П.Болор, Л.Дэлгэрцэцэг, Я.Урнаа нарыг оролцуулан хийж, нэхэмжлэл, иргэний хэрэг, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журмыг шинэчлэн батлах тухай асуудлыг хэлэлцэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.2.5, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 78 дугаар зүйлийн 78.1, 78.2, 78.6, 75<sup>1</sup>.1, Нийт шүүгчийн чуулганы 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 4 дугаартай тогтоолоор батлагдсан “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам”-ын 1.1-д заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Хэрэг хуваарилах шүүгчдийн дарааллыг тогтоох.

1.1. Иргэний хэргийг дагнан шийдвэрлэх шүүгчид нэхэмжлэл, иргэний хэрэг, гомдол, хүсэлт, шүүхийн даалгавар хуваарилах дарааллыг сугалаагаар,

1.1.1. Шүүгч П.Болор,

1.1.2. Шүүгч Л.Дэлгэрцэцэг;

1.1.3. Шүүгч Я.Урнаа гэх тойрог үүсгэж, иргэний хэргийн нэгдсэн системд байршуулахыг шүүхийн Тамгын газрын мэдээлэл, технологийн мэргэжилтэн /Д.Цэвээндорж/-д даалгасгай.

1.2. Иргэний хэргийг дагнан шийдвэрлэх бүх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарсан, эсхүл тэдгээрийг ээлжийн амралттай, ажлын 5 өдөр, түүнээс дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, томилолттой үед нэхэмжлэл, иргэний хэрэг, гомдол, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх шүүгчийг

1.2.1. Ерөнхий шүүгч Б.Гансүх гэх дарааллаар тогтоосгай.

851260029

1.3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт зааснаар гаргасан гомдол, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлтийг тухайн шийдвэр, тогтоол, захирамжийг гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс бусад энэ тогтоолын 1.1.-т заасан иргэний хэрэг дагнан шийдвэрлэх шүүгчид гар аргаар, ийнхүү хуваарилах боломжгүй бол энэ тогтоолын 1.2-т заасан эрүүгийн хэрэг дагнан шийдвэрлэх шүүгчид гар аргаар хуваарилахаар тогтоосугай.

## 2. Шүүх бүрэлдэхүүн болон даргалагчийг томилох

2.1. Иргэний хэрэг, гомдол, хүсэлтийг шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэх тохиолдолд тухайн хэрэг, гомдол, хүсэлт хуваарилагдсан шүүгч шүүх хуралдааныг даргалахаар тогтоосугай.

2.2. Бүрэлдэхүүнтэйгээр иргэний хэрэг, гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэхэд энэ тогтоолын 1.1-д заасан иргэний хэрэг дагнан шийдвэрлэх шүүгчид оролцох боломжгүй тохиолдолд эрүүгийн хэрэг дагнан шийдвэрлэх шүүгч нараас шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгчийг

2.2.1. Ерөнхий шүүгч Б.Гансүх гэх дарааллаар тогтоосугай.

2.3. Тус шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд орох тохиолдолд сугалаагаар тогтоосон,

2.3.1. Шүүгч Л.Дэлгэрцэцэг,

2.3.2. Шүүгч П.Болор;

2.3.3. Шүүгч Я.Урнаа

2.3.4. Ерөнхий шүүгч Б.Гансүх гэх дарааллыг баримтлах бөгөөд тухайн шүүгч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх бүрэлдэхүүнд оролцох боломжгүй тохиолдолд дараагийн шүүгчийг томилуулан оролцуулсугай.

2.4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.6-д заасны дагуу тодорхой хэргийг хянан хэлэлцэх шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөж, Ерөнхий шүүгчийн захирамжаар өөр шүүхийн шүүгчийг томилж, шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар тогтоосугай.

## 3. Хэрэг хуваарилах журмыг батлах.

3.1. “Нэхэмжлэл, иргэний хэрэг, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам”-ыг хавсралтаар баталсугай.

3.2. “Нэхэмжлэл, иргэний хэрэг, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам”-ыг Увс аймгийн шүүхийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэйгээр байршуулахыг мэдээлэл, технологийн мэргэжилтэн /Д.Цэвээндорж/-д даалгасугай.


## 4. Бусад.

4.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.5-д заасны дагуу тухайн жилийн турш шүүгчийн ажлын ачаалал ихэссэн, ажиллах шүүгчдийн тоо нэмэгдсэн, хасагдсаны улмаас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78.1, 78.2-т заасны дагуу хянан шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Ерөнхий шүүгч, түүний эзгүйд Ерөнхий шүүгчийн үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа шүүгч тухай бүр Шүүгчдийн зөвлөгөөнийг зарлан хуралдуулж, хэргийг дахин хуваарилах эсэх асуудлыг шийдвэрлэхээр тогтоосугай.

4.2. Энэхүү тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоож, "Иргэний хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваариалах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам" батлах тухай 2025 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 318/ЗТ2025/00038 дугаартай тогтоол, түүний хавсралтыг энэ тогтоолыг дагаж мөрдсөн өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4.3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий шүүгч /Б.Гансүх/, зохион байгуулалт, биелэлтийг хангаж ажиллахыг Тамгын газрын дарга /Л.Баттулга/ нарт тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД



Б.ГАНСҮХ  
П.БОЛОР  
Л.ДЭЛГЭРЦЭЦЭГ  
Я.УРНАА

Нэхэмжлэл, иргэний хэрэг, гомдол, хүсэлт хүлээн авах,  
хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч,  
шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүхэд хүлээн авсан нэхэмжлэл, иргэний хэрэг, гомдол, хүсэлтийг шүүгчид хуваарилахад энэхүү журмыг баримтална.

1.2. Нэхэмжлэл, иргэний хэрэг, гомдол, хүсэлтийг тус шүүхийн Мэдээлэл, лавлагааны мэргэжилтэн ажлын өдөр, ажлын цагт ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авч, бүртгэлд бүртгэж, хүлээн авсан тэмдэглэгээ хийж, шүүгчид хүлээлгэн өгнө.

Хоёр: Иргэний хэрэг хуваарилах арга

2.1. Шүүхэд шинээр ирсэн нэхэмжлэл, хэрэг, гомдол, хүсэлт, шүүхийн даалгаврыг иргэний хэргийн нэгдсэн системээс сугалаагаар тогтоосон тойрог дотор санамсаргүй аргаар шүүгчид хуваарилна.

2.2. Давж заалдах болон хяналтын шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болгож, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан иргэний хэргийг урьд хянан шийдвэрлэсэн шүүгчид гар аргаар хуваарилна. Урьд шийдвэрлэсэн шүүгч ажлын 5 өдөр, түүнээс дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, томилолттой болон ээлжийн амралттай, эзгүй тохиолдолд тогтоолын 1.1.-т заасан сугалаагаар тогтоосон дарааллаар тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

- “хуулийг буруу хэрэглэсэн” үндэслэлээр хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан иргэний хэргийг урьд хянан шийдвэрлэсэн шүүгчээс бусад шүүгчид хуваарилна. Иргэний хэргийг дагнан шийдвэрлэх өөр шүүгч байхгүй тохиолдолд энэ заалт хамаарахгүй.

2.3. Шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянаж шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр тогтоосон, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг буцаасан бол хүчингүй болгосон иргэний хэрэг, тухайн асуудлаар дахин гаргасан нэхэмжлэлийг урьд шийдвэрлэсэн шүүгчид гар аргаар хуваарилна.

- Шүүгч ажлын 5 өдөр, түүнээс дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, томилолттой болон ээлжийн амралттай, эзгүй тохиолдолд энэ заалт хамаарахгүй ба тогтоолын 1.1-т заасан дарааллаар гар аргаар, ийнхүү хуваарилах боломжгүй бол 1.2-т заасан дарааллаар гар аргаар хуваарилна.

2.4. Шүүгчийг татгалзан гаргасан, шүүгч өөрөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарсан, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргасан тохиолдолд уг хэргийг бусад шүүгчид тогтоолын 1.1-т заасан сугалаагаар тогтоосон дарааллаар гар аргаар хуваарилна.

2.5. Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлт, давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах хугацаа сэргээлгэх тухай хүсэлтийг тухайн шийдвэр, захирамж, тогтоолыг гаргасан шүүгчид гар аргаар хуваарилна.

- Тухайн шүүгч ажлын 5 өдөр, түүнээс дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, томилолттой болон ээлжийн амралттай, эзгүй тохиолдолд тогтоолын 1.1-д заасан сугалаагаар тогтоосон тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

2.6. Адил шатны өөр шүүхээс шилжиж ирсэн хэрэг, харьяалал тогтоолгож ирүүлсэн хэргийг тогтоолын 1.1-д заасан сугалаагаар тогтоосон дарааллаар гар аргаар хуваарилна.

2.7. Хэргийг нэгтгэхдээ хугацааны хувьд эхэлж иргэний хэрэг үүсгэн, ажиллагаа хийгдсэн иргэний хэрэгт нэгтгэх, харин нэгтгэн гаргасан нэхэмжлэлийн шаардлагаас нэг буюу хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлагыг тусгаарласан тохиолдолд уг тусгаарлагдсан нэхэмжлэлийг системээс тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

#### Гурав: Бусад

3.1. Шүүгч ажлын 5 өдөр, түүнээс дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, томилолттой үед тухайн өдрөөс шүүгчид нэхэмжлэл, иргэний хэрэг, хүсэлт, гомдол хуваарилахыг зогсоож, ажилд орсон өдрөөс эхлэн хуваарилна.

3.2. Шүүгч ээлжийн амралт эдлэх тохиолдолд ажлын 1 өдрийн өмнө тухайн шүүгчид нэхэмжлэл, иргэний хэрэг, гомдол, хүсэлт хуваарилахыг зогсоож, ажилд орсон өдрөөс эхлэн хуваарилна.

3.3. Шүүгч ажлын 5 өдөр, түүнээс дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, томилолттой үед тухайн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа нэхэмжлэл, иргэний хэрэг, хүсэлт, гомдлыг бусад шүүгчид хуваарилах эсэхийг тухай бүр Шүүгчдийн зөвлөгөөнөөр шийднэ.

3.4. Шүүгч ээлжийн амралт эдлэх тохиолдолд тухайн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа нэхэмжлэл, иргэний хэрэг, хүсэлт, гомдлыг иргэний хэрэг дагнан шийдвэрлэх шүүгчид сугалаагаар хуваарилж, шилжүүлнэ.

3.5. Шүүгч өвчтэй, чөлөөтэй, томилолттой болон ээлжийн амралтын хугацаа дуусаж ажилд орох үед түүний бусад шүүгчид шилжүүлсэн хэргээс шийдвэрлэгдээгүй үлдсэн хэргийг тухайн шүүгчид буцаан шилжүүлнэ.

3.6. Нэхэмжлэл, иргэний хэрэг, гомдол, хүсэлт хуваарилахтай холбоотой бусад асуудлыг тухай бүрд нь Шүүгчдийн зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ.

УВС АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН